



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 10 сарын 01 өдөр

Дугаар СХШ-2024/10

Сүхбаатар сум

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ДҮН

**Нэг: Хяналт шалгалтын зорилго, хамарсан хүрээ, хугацаа, шалгуулсан
байгууллагын чиг үүрэг, зохион байгуулалт**

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.16, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Дотоод аудитын дүрэм”, Монгол Улсын Сангийн Сайдын баталсан 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн СХШХ/07 дугаартай “Татварын Ерөнхий газар, түүний харьяа газар, газрын үйл ажиллагаанд хийх нэгдсэн хяналт шалгалтын удирдамж”-ийг тус тус үндэслэн Сэлэнгэ аймгийн Татварын газарт хяналт шалгалт хийлээ.

Сэлэнгэ аймгийн Татварын газрын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаа нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Татварын багц хуулиуд болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн актуудын дагуу явагдаж буй эсэхийг хянан шалгаж, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгч засаж залруулах, арилгуулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой.

Шалгалтыг Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны дарга, улсын ахлах байцаагч Т.Одсүрэн ахалж, дотоод аудитор, улсын байцаагч Ц.Уртнасан, дотоод аудитор Х.Батбаатар, Г.Дорждэрэм нарын бүрэлдэхүүнтэйгээр 2024 оны 09-р сарын 02-ны өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Шалгалтад Татварын газрын 2022, 2023 оны хугацааны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагааг удирдамжид заасан асуудлын хүрээнд холбогдох баримт материалыг хамруулав.

Байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, үр дүн, өмч хөрөнгийн бүртгэлт, хандив тусламжийн хөрөнгө, иргэн аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ, хэрэгжилт, шилэн дансны мэдээлэл байршуулалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналт

Улс, орон нутгийн төсөвт оруулах татварын орлогын ногдуулалт, бүрдүүлэлт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татвартай холбоотой ажил үйлчилгээ, үнэт цаасны

тооцоо, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төрийн өмчийн газрын эзэмшиж, ашигласны төлөө ногдуулсан төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байдал

-Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, татварын хуулиуд холбогдох хууль тогтоомж, журмууд хэрхэн хэрэгжиж байгаа байдалтай танилцаж, тулгарч буй асуудлуудыг дүгнэх, илэрсэн зөрчил дутагдлыг засаж сайжруулах арга хэмжээний санал боловсруулах.

-Байгууллагын үндсэн мэдээлэл

Сэлэнгэ аймгийн Татварын газар нь ТЕГ-ын даргын 2022 оны 05 сарын 18 өдрийн А/56 дугаар тушаал 57 орон тоотойгоор, 2023 оны 03 сарын 01 өдрийн А/36 дугаар тушаалаар 56 орон тоотойгоор баталсан бүтэц, чиг үүргийн дагуу Захиргаа хуулийн тасаг, Бичил татвар төлөгчтэй харилцах тасаг, Жижиг татварын төлөгчтэй харилцах тасаг, Татварын хяналт шалгалтын тасаг, Мандал сумын татварын тасаг гэсэн бүтэцтэйгээр ажилласан байна.

Сэлэнгэ аймгийн Татварын газар нь улсын бүртгэлийн 9055681 тоот регистртэй, Төрийн банкны 100130011001 тоот данс, нэмэлт санхүүжилтийн 100130011401 тоот дансанд болон санхүүгийн баримтад 1-р гарын үсгийг газрын дарга Ц.Лхагвадорж, 2-р гарын үсгийг Татварын улсын байцаагч, нягтлан бодогч Ш.Энхбаяр нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, мэдээ тайланг гаргаж ирсэн байна.

Сэлэнгэ аймгийн Татварын газар нь 2022 онд 57 орон тоотойгоос гүйцэтгэлээр 47 албан хаагч ажилласан. Тус онд 1,148,094.3 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй, 960,291.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр 187,803.3 мянган төгрөг хэмнэсэн. Жилийн орлогыг шалгахад үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө 9,639.7 мянган төгрөг, бараа материал 9,213.9 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 5,700.0 мянган төгрөг, бусад орлого 35.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөцөөс 6,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого нийтдээ 2022 онд 1,178,682.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

2023 онд 56 орон тоотойгоос гүйцэтгэлээр 46 албан хаагч ажилласан. Тус онд 1,832,708.4 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй, 1,577,220.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэйгээр 255,487.4 мянган төгрөг хэмнэсэн. Жилийн орлогыг шалгахад үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө 1,333,720.4 мянган төгрөг, бараа материал 1,697.1 мянган төгрөг, бусад орлого 35.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөцөөс 10,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого нийтдээ 2023 онд 3,178,160.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Мөнгөний зарцуулалтыг шалгахад 2022 онд 1,159,829.3 мянган төгрөгийн орлоготой, үүнээс зардлын ангиллаар цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 701,668.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 89,131.5 мянган төгрөг, тогтмол зардалд 23,091.4 мянган төгрөг, хангамж бараа материалд 19,995.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварт 1,802.5 мянган төгрөг, томилолт 3,185.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 93,013.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 11,552.5 мянган төгрөг, тэтгэвэр тэтгэмжид

22,934.9 мянган төгрөг бүгд 966,376.0 мянган төгрөгийг зарцуулж, тухайн жилийн төсвөөс хэмнэсэн 187,803.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн 5,650.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Мөнгөний зарцуулалтыг шалгахад 2023 онд 1,842,743.4 мянган төгрөгийн орлоготой, үүнээс зардлын ангиллаар цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 1,199,553.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 152,912.6 мянган төгрөг, тогтмол зардалд 26,900.1 мянган төгрөг, хангамж бараа материалд 21,032.9 мянган төгрөг, эд хогшил урсгал засварт 5,398.1 мянган төгрөг, томилолт 10,311.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 97,725.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 17,025.2 мянган төгрөг, тэтгэвэр тэтгэмжид 56,397.7 мянган төгрөг бүгд 1,587,256.0 мянган төгрөгийг зарцуулж, тухайн жилийн төсвөөс хэмнэсэн 255,487.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2022 онд үнэ төлбөргүй гарсан зардал 69.6 мянган төгрөгийг, 2023 онд үнэ төлбөргүй гарсан зардал 10.6 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд тусгасан байна.

Хоёр. Шалгалтад хамрагдах асуудлууд

2.1. Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар, журмын хэрэгжилт

Байгууллагын үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулийг тус тус хэрэгжүүлэн ажилласан байна.

Татварын хууль тогтоомж сурталчлах, мэдээ мэдээлэл гарын авлагаар хангах, зөвлөмж өгөх ажлын хүрээнд нээлттэй хаалганы өдөр, цахим болон татварын сургалтыг аймгийн хэмжээнд, аж ахуйн нэгжүүд дээр зохион байгуулах, гарын авлага тарааж өгөх зэргээр байнгын сурталчилгаа хийж ажиллан Татварын газрын үйл ажиллагаанд татварын ерөнхий хууль, холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлж ажилласан байна.

2.2. Улс, орон нутгийн төсөвт оруулах татварын орлогын бүрдүүлэлт, тайлагналт

Сэлэнгэ аймгийн хэмжээнд татвар төлөгч аж ахуйн нэгж 4469, иргэн 8387 бүртгэлтэй байна. Жил бүр хөндлөнгийн мэдээллийг цуглуулахаар 566 байгууллага нэгжид хүсэлт тавьж мэдээллийг хүлээн авч боловсруулан программд оруулсан байна.

-Татварын орлогын ногдуулалт, бүрдүүлэлт:

Татварын орлого 2022 онд 1,754,684.2 мянган төгрөг буюу 3.3 хувиар, 2023 онд 9,552,154.1 мянган төгрөг буюу 16.4 хувиар тус тус давуулан төсвийн орлого бүрдүүлсэн байна.

Хүснэгт-1					/мянган төгрөг/	
№	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
1	2022 он	52,669,237.5	54,423,921.7	1,754,684.3	103.3	
2	2023 он	58,390,565.3	67,942,719.4	9,552,154.1	116.4	

Татварын орлогыг улсын, аймгийн, сумын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг сум бүрээр гаргаж дүгнэлт хийлээ. Үүнд:

-Улсын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг 2022 онд 1,011,535.6 мянган төгрөг буюу 22.0 хувиар, 2023 онд 1,705,708.3 мянган төгрөг буюу 27.3 хувиар давуулан биелүүлсэн байна. Сум бүрээр татварын орлогын гүйцэтгэлийг 2 жилээр гаргахад 2022 онд Сүхбаатар, Орхонтуул сумд төлөвлөгөөг хараахан биелүүлээгүй буюу 97.2 – 97.4 хувийн гүйцэтгэлтэй байгаа бол бусад сумд 0.9 хувиас 2.7 дахин илүү орлого оруулсан, 2023 онд Хүдэр, Цагааннуур, Сайхан сумдын төлөвлөгөөний биелэлт биелээгүй буюу 64.1 – 91.4 хувийн гүйцэтгэлтэй бол бусад сумд төлөвлөгөөний биелэлтийг 1.6 хувиас 2.7 дахин давуулан биелүүлсэн нь нийт дүнгээрээ төлөвлөгөө давуулан биелүүлэхэд голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт-2								/мянган төгрөг/	
№	Сумын нэр	2022 он			2023 он			Хувь	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь		
1	Алтанбулаг	305,728.7	472,054.9	154.4	475,500.0	483,308.9	101.6		
2	Баруунбүрэн	38,069.2	65,061.7	170.9	137,500.0	195,221.1	142.0		
3	Баянгол	42,205.8	86,010.9	2.0 ¹	211,400.0	272,038.1	128.7		
4	Ерөө	170,420.0	221,584.4	130.0	251,500.0	560,956.6	2.2 ¹		
5	Жавхлант	43,003.5	43,400.6	100.9	57,500.0	79,421.5	138.1		
6	Зүүнбүрэн	151,524.2	177,479.6	117.1	188,000.0	240,858.5	128.1		
7	Мандал	820,140.1	829,640.3	101.2	1,023,500.0	1,304,468.4	127.5		
8	Орхон	6,581.6	12,257.0	186.2	19,500.0	26,685.3	136.8		
9	Орхонтуул	79,907.6	77,829.3	97.4	149,000.0	185,211.2	124.3		
10	Сайхан	481,409.7	589,018.7	122.4	715,537.0	654,130.8	91.4		
11	Сант	2,451.9	6,721.1	2.7 ¹	6,500.0	7,126.4	109.6		
12	Сүхбаатар	1,576,339.1	1,532,048.2	97.2	1,477,800.0	2,384,017.8	161.3		
13	Түшиг	298,600.1	434,586.1	145.5	120,500.0	329,215.0	2.7 ¹		
14	Хушаат	103,076.8	132,473.9	128.5	242,500.0	253,836.6	104.7		
15	Хүдэр	160,214.6	292,092.0	182.3	369,000.0	236,648.9	64.1		
16	Цагааннуур	292,939.4	604,235.3	2.1 ¹	774,600.0	685,929.6	88.6		
17	Шаамар	16,567.7	24,221.5	146.2	28,500.0	54,970.6	192.9		
	Дүн	4,589,179.9	5,600,715.5	122.0	6,248,336.9	7,954,045.3	127.3		

¹ Дахин их

-Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Аймгийн төсөвт оруулах орлого 2022 онд 68.4 хувьтай байгаа нь Алтанбулаг, Баянгол, Ерөө, Мандал, Хүдэр сумдын ААНОАТ /40%/ -н татвар төлөгч зарим аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор тус орлого

тасарсан нь голлон нөлөөлсөн байна. Жавхлант, Сүхбаатар, Сайхан сумдын орлогын төлөвлөгөө 2.2 – 22.8 дахин өссөн нь тухайн жилийн аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөг төсөвлөхдөө бодитой төсөвлөөгүйтэй холбоотой байна. 2023 онд орлогын төлөвлөгөөг 5.2 хувиар давуулан биелүүлэхэд Баянгол, Ерөө сумаас бусад сумд орлогын төлөвлөгөөг 1.3 – 4.5 дахин давуулан биелүүлсэн нь голлон нөлөөлсөн байна. Орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсэн шалтгаан нь тухайн жилийн орлогын төлөвлөгөөг төсөвлөхдөө татварын орлогын төлөвлөгөөг бодитоор орлогын төрөл бүр дээр төлөвлөгөө тусгаж өгдөггүйтэй шууд холбоотой байна.

Хүснэгт-3

/мянган төгрөг/

№	Сумын нэр	2022 он			2023 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Алтанбулаг	123,998.3	61,968.2	50.0	145,760.2	193,515.2	132.8
2	Баруунбүрэн	26,998.8	38,690.1	143.3	33,984.0	141,273.0	4.2 ¹
3	Баянгол	1,662,838.7	445,898.7	26.8	10,872,471.7	10,811,890.9	99.4
4	Ерөө	9,792,953.5	540,305.2	5.5	4,540,865.5	2,841,211.8	62.6
5	Жавхлант	17,499.1	39,335.0	2.2 ¹	22,125.3	43,270.1	195.6
6	Зүүнбүрэн	35,998.9	53,305.8	148.1	25,309.2	108,148.1	4.2 ¹
7	Мандал	7,142,843.9	1,697,340.5	23.8	1,045,944.5	2,310,550.4	2.2 ¹
8	Орхон	19,599.1	25,065.6	127.9	16,423.5	33,485.0	2.0 ¹
9	Орхонтуул	38,998.7	46,862.3	120.2	28,879.8	71,138.8	2.5 ¹
10	Сайхан	136,993.0	3,025,857.4	22.8 ¹	131,036.1	317,978.9	2.4 ¹
11	Сант	11,999.2	15,474.6	129.0	10,785.7	20,832.5	193.1
12	Сүхбаатар	509,988.8	7,894,333.8	15.4 ¹	798,781.7	1,331,392.5	166.7
13	Түшиг	15,999.4	20,230.7	126.4	13,312.7	73,076.1	5.5 ¹
14	Хушаат	25,999.2	35,489.9	136.5	50,314.7	119,905.0	2.4 ¹
15	Хүдэр	1,313,244.3	258,140.1	19.7	91,818.0	118,654.6	129.2
16	Цагааннуур	182,997.7	194,164.9	106.1	189,617.3	340,754.0	179.7
17	Шаамар	21,049.3	36,299.2	172.4	22,570.0	101,529.9	4.5 ¹
	Дүн	21,080,000.0	14,428,761.8	68.4	18,040,000.0	18,978,606.9	105.2

¹ Дахин их

-Сумын орлого

Сэлэнгэ аймгийн 17 сумын төсвийн орлого 2022 онд 127.4 хувь, 2023 онд 120.3 хувийн биелэлттэй байна. 2022 онд Сант, Хушаат сумдын сумын төсвийн орлого биелээгүй бол бусад сумд орлогын төлөвлөгөөг 2.3 хувиас 3.2 дахин давуулан биелүүлсэн байна. Сант, Хушаат сумдын орлогын төлөвлөгөө биелээгүй шалтгаан нь малын тоо толгойн албан татварын орлогыг төвлөрүүлээгүйтэй холбоотой байгаа бол орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн сумд нь тухайн жилийн орлогын төлөвлөөг өмнөх оны гүйцэтгэл дээр тулгуурлан бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна. 2023 онд Зүүнбүрэн сумын төлөвлөгөөний биелэлт 87.9 хувьтай байсан бол бусад сумууд 6,907,633.9 мянган төгрөг төлөвлөгөөнөөс илүү бүрдүүлсэн байна. Зүүнбүрэн сумын орлогын төлөвлөгөө биелээгүй шалтгаан нь малын тоо толгойн албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө биелээгүйтэй холбоотой бол бусад сумдын орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн шалтгаан нь тухайн онд төлөвлөөгүй орлого орсон мөн орлогын

төлөвлөгөөг төсөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл дээр тулгуурлан төсөвлөөгүйтэй холбоотой байна.

Хүснэгт-4

/мянган төгрөг/

№	Сумын нэр	2022 он			2023 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Алтанбулаг	498,461.7	600,817.6	120.5	490,724.7	571,964.3	116.6
2	Баруунбүрэн	348,175.7	826,314.4	2.3 ¹	668,305.4	653,356.8	97.8
3	Баянгол	914,398.0	935,024.5	102.3	1,261,742.6	1,543,001.4	122.3
4	Ерөө	4,174,884.8	5,768,816.4	138.2	5,723,728.8	7,346,574.9	128.4
5	Жавхлант	301,627.8	299,364.9	99.2	395,680.5	401,455.0	101.5
6	Зүүнбүрэн	396,638.0	407,065.2	102.6	744,763.6	654,381.0	87.9
7	Мандал	6,081,554.5	7,918,525.4	130.2	6,560,901.0	9,069,167.4	138.2
8	Орхон	309,437.7	328,172.5	106.1	395,099.2	513,168.7	129.9
9	Орхонтуул	233,112.0	410,070.1	175.9	547,339.3	706,850.4	129.1
10	Сайхан	3,836,934.6	3,798,174.0	99.0	3,549,546.8	3,795,830.1	106.9
11	Сант	248,442.9	226,610.6	91.2	306,713.4	379,261.4	123.7
12	Сүхбаатар	6,456,769.6	6,902,544.9	106.9	9,496,120.9	9,475,290.8	99.8
13	Түшиг	254,931.5	729,250.9	2.8 ¹	416,855.6	700,750.7	168.1
14	Хушаат	648,299.8	431,234.8	66.5	455,012.3	529,027.7	116.3
15	Хүдэр	1,018,204.1	3,231,338.7	3.2 ¹	1,338,486.4	2,486,898.1	185.8
16	Цагааннуур	917,511.2	1,044,326.4	113.8	1,206,248.9	1,533,274.0	127.1
17	Шаамар	360,673.7	536,793.1	148.8	545,164.0	649,814.5	119.2
	Дүн	27,000,057.6	34,394,444.5	127.4	34,102,433.4	41,010,067.3	120.3

¹ Дахин их

Дээрх хүснэгтээс харахад татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелүүлсэн боловч орлогын нэр төрлөөр үзэхэд малын тоо толгой албан татвар жил бүр тасарсан байна. Малын тоо толгойн албан татварын ногдуулалт, төлөвлөгөө, гүйцэтгэлийг сумдаар нь харуулбал.

Малын тоо толгойн албан татвар, 2022 он

Хүснэгт -5

/мянган төгрөг/

Сумын нэр	2022 он			
	Ногдуулбал зохих албан татвар	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү
Алтанбулаг	66,647.8 214,77	25,000.0	29,483.7	4,483.7
Баруунбүрэн	3.5	-	167,730.9	167,730.9
Баянгол	331,832.0	100,000.0	232,903.4	132,903.4
Ерөө	164,968.0	150,000.0	109,523.6	(40,476.4)
Жавхлант	143,167.6	104,184.4	43,530.4	(60,654.0)
Зүүнбүрэн	113,803.0	88,868.0	76,146.0	(12,722.0)
Мандал	240,976.0	254,531.7	133,066.5	(121,465.2)
Орхон	156,934.0	100,500.3	91,396.5	(9,103.8)
Орхонтуул	357,788.0	-	96,086.2	96,086.2
Сайхан	138,003.8	50,000.0	52,877.0	2,877.0

Сант	138,011.0	133,935.0	85,612.0	(48,323.0)
Сүхбаатар	36,290.0	20,479.0	12,976.8	(7,502.2)
Түшиг	65,708.5	-	42,904.0	42,904.0
Хушаат	222,587.3	423,587.0	63,320.3	(360,266.7)
Хүдэр	43,215.5	-	32,535.4	32,535.4
Цагааннуур	377,268.0	355,041.2	76,190.2	(278,851.0)
Шаамар	52,052.0	-	42,785.0	42,785.0
Дүн	2,864,026.0	1,806,126.6	1,389,067.9	(417,058.7)

Малын тоо толгойн албан татвар, 2023 он

Сумын нэр	2023 он			
	Ногдуулбал зохих албан татвар	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү
Алтанбулаг	63,471.5	46,000.0	51,679.6	5,679.6
Баруунбүрэн	213,415.0	214,773.5	226,239.5	11,466.0
Баянгол	360,634.0	298,500.0	230,247.4	(68,252.6)
Ерөө	158,986.0	158,331.8	109,778.2	(48,553.6)
Жавхлант	148,039.6	148,039.6	124,321.8	(23,717.8)
Зүүнбүрэн	108,781.0	115,763.2	67,970.6	(47,792.6)
Мандал	245,158.0	240,976.0	265,062.6	24,086.6
Орхон	164,487.0	156,943.0	155,517.3	(1,425.7)
Орхонтуул	360,959.0	270,000.0	203,477.3	(66,522.7)
Сайхан	145,537.6	226,001.8	112,865.5	(113,136.3)
Сант	144,343.0	144,343.0	106,323.3	(38,019.7)
Сүхбаатар	31,377.5	36,290.0	15,123.5	(21,166.5)
Түшиг	68,273.5	68,273.5	32,487.5	(35,786.0)
Хушаат	219,231.8	240,000.0	202,529.9	(37,470.1)
Хүдэр	47,127.1	37,000.0	35,068.3	(1,931.8)
Цагааннуур	368,650.0	350,000.0	193,262.1	(156,737.9)
Шаамар	47,580.0	42,000.0	39,642.7	(2,357.3)
Дүн	2,896,051.6	2,793,235.4	2,171,596.9	(621,638.5)

2022 онд малын тоо толгойн албан татвар нийт 2,864,026.0 мянган төгрөг ногдохоор байсан бол 1,806,126.6 мянган төгрөг ногдуулсан байна.

2023 онд малын тоо толгойн албан татвар нийт 2,896,051.6 мянган төгрөг ногдуулахаар байсан бол 2,793,235.4 мянган төгрөг ногдуулсан нь татварын орлогын төлөвлөгөөг үндэслэлгүйгээр Баруунбүрэн, Зүүнбүрэн, Сайхан, Сүхбаатар, Хушаат сумууд 114,485.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бусад сумд 217,301.8 мянган төгрөгөөр дутуу төсөвлөсөн байна. Мөн батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү буюу 757,183.7 мянган төгрөгийг 2023 онд төсөвт төвлөрүүлээгүй байна.

2.3.Татварын чөлөөлөлт, хөнгөлөлт

2022 онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 4 аж ахуйн нэгжийг 561,390.9 мянган төгрөгийг, 2023 онд 31 аж ахуйн нэгжийн 1,119,104.4 мянган төгрөгийг тус тус албан татвараас чөлөөлж, 2022 онд 139 аж ахуйн нэгжийн 2,212,264.3 мянган төгрөгт, 2023 онд 133 аж ахуйн нэгжийн 2,548,823.3 мянган төгрөгт тус тус албан татварын хөнгөлөлт эдлүүлсэн байна.

Хувь хүний орлогын албан татварын хуулийн хүрээнд татварын баримт материалыг шалгах ажлын хэсэг томилон шалгалт хийж баримтын бүрдэлттэй иргэдэд татварын буцаан олголтыг олгуулах албан бичгийг аймгийн Санхүү төрийн сангийн газарт хүргүүлж 2022 онд ирүүлсэн 1668 иргэнд 1,671,857.1 мянган төгрөгийг 2023 онд, 2023 онд 1644 иргэний ирүүлсэн баримтаар 2,193,806.7 мянган төгрөгийг 2024 онд тооцон олгуулсан байна.

2.4.Иргэн, аж ахуй нэгж байгууллагын төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө ногдуулсан төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байдал

2022 онд Сэлэнгэ аймгийн татварын орлогын дүнд газрын төлбөр 151,811.7 мянган төгрөг, 2023 онд 17,483.6 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Сумдын 2022 оны төсвийн орлогод газрын төлбөр ногдуулалтыг 1,405,488.9 мянган төгрөгөөр төсөвлөснөөс гүйцэтгэлээр 86.0 хувь буюу 1,209,069.0 мянган төгрөг төвлөрүүлсэн бол 2023 онд 1,376,277.9 мянган төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 124.3 хувь буюу 1,710,937.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аймгийн орлогын төлөвлөгөөнд газрын төлбөр ногдуулалт

Хүснэгт-6

/мянган төгрөг/

№	Сумын нэр	2022 онд төлөгдсөн газрын төлбөр	2023 онд төлөгдсөн газрын төлбөр
1	Алтанбулаг	35.4	102.9
2	Баруунбүрэн	2,169.1	2,492.8
3	Баянгол	4,776.7	629.1
4	Ерөө	3,361.4	2,703.8
5	Жавхлант	6,488.3	369.6
6	Зүүнбүрэн	418.9	204.1
7	Мандал	36,698.5	1,650.4
8	Орхон	758.3	57.9
9	Орхонтуул	625.8	202.3
10	Сайхан	3,697.1	780.8
11	Сант	204.4	222.5
12	Сүхбаатар	19,515.5	2,737.3
13	Түшиг	2,514.1	29.2
14	Хушаат	4,131.2	786.4
15	Хүдэр	63,469.2	3,341.4
16	Цагааннуур	2,527.9	641.6
17	Шаамар	419.9	531.5
	Дүн	151,811.7	17,483.6

Сумын орлогын төлөвлөгөөнд газрын төлбөр ногдуулалт

Хүснэгт-7

/мянган төгрөг/

№	Сумын нэр	2022 он			2023 он		
		Төлбөр ногдуулалт	Төлсөн	Хувь	Төлбөр ногдуулалт	Төлсөн	Хувь
1	Алтанбулаг	23,743.0	8.2	0.0	-	-	0.0
2	Баруунбүрэн	29,546.6	26,640.7	90.2	29,547.0	31,530.5	106.7

3	Баянгол	64,715.9	80,124.2	123.8	66,621.0	121,544.3	182.4
4	Ерөө	275,435.3	305,172.0	110.8	275,436.0	331,691.6	120.4
5	Жавхлант	24,182.5	23,223.7	96.0	24,183.0	21,649.1	89.5
6	Зүүнбүрэн	24,125.0	21,658.5	89.8	23,090.5	19,562.2	84.7
7	Мандал	291,340.1	156,101.8	53.6	300,000.0	339,685.5	113.2
8	Орхон	77,446.4	54,589.6	70.5	57,446.0	23,020.2	40.1
9	Орхонтуул	28,633.0	21,194.4	74.0	28,633.0	146,410.0	5.1 ¹
10	Сайхан	49,194.6	46,301.8	94.1	49,195.0	52,321.7	106.4
11	Сант	10,911.0	6,300.5	57.7	10,911.0	10,983.2	100.7
12	Сүхбаатар	50,000.0	68,382.1	136.8	60,000.0	76,332.5	127.2
13	Түшиг	9,264.0	150.0	1.6	9,264.0	29,141.5	3.1 ¹
14	Хушаат	25,808.0	30,465.8	118.0	25,808.0	35,260.7	136.6
15	Хүдэр	300,940.4	284,955.4	94.7	300,940.0	364,185.6	121.0
16	Цагааннуур	68,384.4	49,988.3	73.1	63,384.4	59,316.1	93.6
17	Шаамар	51,818.7	33,812.0	65.3	51,819.0	48,302.7	93.2
	Дүн	1,405,488.9	1,209,069.0	86.0	1,376,277.9	1,710,937.4	124.3

¹ Дахин их

2.5.Улсын төсөв, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив, зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгийн зориулалт, зарцуулалт, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгасан байдал, ашиглалт, зээлийн эргэн төлөлт, үр өгөөжийн байдал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 1,324,298.6 мянган төгрөгийн өртөгтэй Татварын газрын барилга, байгууламжийг ТӨБЗГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолоор ашиглалтад хүлээн авч, бүртгэл тайланд тусгасан байна. Сангийн сайдын 2019 оны 38 дугаар эрх шилжүүлэх тушаалаар Сэлэнгэ аймгийн Засаг даргад тухайн барилгын төсвийг зарцуулах эрх шилжүүлсэн. 2021 оны 11 сарын 16-ны өдрийн БУ-88/2021 комиссын актаар барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гарсан боловч ТӨБЗГ-ын тогтоол 2023 онд гарснаар тайлант онд хүлээн авсан байна.

2.6.Санхүүгийн үйл ажиллагааны явц, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэлд тусгасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Сэлэнгэ аймгийн Татварын газрын хөрөнгө эд хогшил, бараа материалын хөдлөл өөрчлөлтийг шалгахад зөрүү гараагүй, байгууллагын даргын тушаалаар томилогдсон өмч хамгаалах комисс нь өмч хөрөнгийн байдалд өөрчлөлт гарах бүрт дүгнэлт гаргаж дотоодын хяналтыг хэрэгжүүлж ирсэн байна.

-Бараа материал: 2022 оны эхний үлдэгдэл 31,312.8 мянган төгрөг, үлдэгдэл 42,548.6 мянган төгрөг. 2023 оны жилийн эцэст 47,207.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, үүний 61.7% нь аж ахуйн материал дансанд үлдэгдэлтэй байна.

Үнэ төлбөргүй бараа материалыг шалгахад 2022 онд ТЕГ-аас нийт 9,213.9 мянган төгрөгийн, 2023 онд нийт 1,697.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч орлогод бүртгэсэн байна.

-2022 онд:

-Үндсэн хөрөнгө:

2022 оны эхэнд 572,139.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бол оны эцэст 534,279.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 37,860.2 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө буурсан байна.

Хөрөнгийн данс бүрээр шалгахад:

-Барилга байгууламж орон сууц данс 2022 оны эхэнд 22,156.8 мянган төгрөг. 2022 оны эхний хагас жилд явуулсан Улсын үзлэг тооллогын хүрээнд холбогдох журам, үүрэг чиглэл, зааварчилгааны дагуу үндсэн хөрөнгийг данснаас данс хооронд шилжүүлэн бүртгэснийг ТӨБЗГ 2022 оны 10 сарын 30 өдөр баталгаажуулсныг үндэслэн тус газрын барилга байгууламжийн хөрөнгөнд бусад үндсэн хөрөнгийн 30,710.0 төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэснээр оны эцэст 52,866.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба бусад үндсэн хөрөнгө данс үлдэгдэлгүй болсон байна.

-Тээврийн хэрэгсэл данс 2022 оны эхэнд 160,800.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 08-ний өдрийн “Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай” 498 тоот тогтоолыг үндэслэн тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Nissan Navara маркийн /MNTCCUD40Z0016939/ 2133СЭҮ улсын дугаартай автомашиныг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр дуудлагын худалдаагаар худалдаж 47,500.0 мянган төгрөгийн үнэтэй элэгдлээ бүрэн нөхсөн автомашиныг данснаас хасаж, оны эцэст 113,300.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

-Машин, тоног төхөөрөмж данс 2022 оны эхэнд 312,697.5 мянган төгрөг, ТЕГ-аас 8,905.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж данснаас дансанд шилжүүлж авснаар оны эцэст 321,602.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

-Тавилга эд хогшил данс 2022 оны эхэнд 32,869.3 мянган төгрөг, ТЕГ-аас 734.6 мянган төгрөгийн ширээ сандал болдог 2 үйлдэлтэй сандлыг данснаас дансанд шилжүүлж авснаар оны эцэст 33,603.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

-ТӨБЗГ-ын 2022 оны 10 сарын 30 өдөр баталгаажуулсан дүнг үндэслэн Биет бус хөрөнгийн 12,906.0 мянган төгрөгийн хөрөнгийг биет бус хөрөнгийн дүн дэх газар эзэмших эрхийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

-2023 онд:

2023 оны эхэнд 534,279.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бол оны эцэст 1,831,191.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 1,296,912.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө өссөн байна.

Хөрөнгийн данс бүрээр шалгахад:

-Барилга байгууламж орон сууц данс 2023 оны эхэнд 52,866.8 мянган төгрөг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 1,324,298.6 мянган төгрөгийн албан конторын барилгыг ТӨБЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 233 тоот тогтоолыг үндэслэн газрын даргын тушаалаар орлогод авснаар оны эцэст 1,377,165.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

-Тээврийн хэрэгсэл данс 2023 оны эхэнд 113,300.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, өөрчлөлт ороогүй.

-Машин, тоног төхөөрөмж данс 2023 оны эхэнд 321,602.6 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А-1/2347 тоот албан бичиг, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/66 тоот тушаалаар ТЕГ-аас балансаас баланст шилжүүлсэн 8,437.8 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авч, ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 685 тоот тогтоолоор 31,898.3 мянган төгрөгийн хөрөнгийг газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/65 тушаалаар данснаас хасаж акталснаар оны эцэст 298,142.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

-Тавилга эд хогшил данс 2023 оны эхэнд 33,603.8 мянган төгрөг, ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 685 тоот тогтоол, газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/65 тушаалаар 4,910.0 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж акталснаар эцэст 28,693.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

-Биет бус хөрөнгийн дүн дэх газар эзэмших эрхийн дансанд 2023 оны эхэнд 12,906.0 мянган төгрөг. Аймгийн засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/339 тоот захирамжаар 82 мкв газрыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтээр холбогдох үнэлгээг үндэслэн 984.0 мянган төгрөгөөр орлогод авч оны эцэст 13,890.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлийн журнал хөтөлсөн, санхүүгийн тайлангууд, нэмэлт толилуулгыг гаргаж тайлагнасан, баримт эмх цэгцтэй байна.

Сэлэнгэ аймгийн Татварын газар нь 2022 оны жилийн эхэнд дансны үнэ 120,098.2 мянган төгрөгийн, 2023 оны жилийн эхэнд дансны үнэ 96,662.4 мянган төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө үйл ажиллагаандаа ашиглаж байсан боловч судалгаа тооцоог гаргаж холбогдох газарт хүргүүлээгүй, дахин үнэлгээ хийгээгүй байна.

2.7.Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдал, зарцуулалт, тооцоо бодолт

Сэлэнгэ аймгийн Татварын газрын 2022-2023 оны ажиллагсдын орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн батлагдсан төсөв, гүйцэтгэл хийсэн дүн шинжилгээ хийлээ:

Хүснэгт -8

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	2022 он			2023 он		
	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Хэмнэлт(+) Хэтрэлт(-)	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Хэмнэлт(+) Хэтрэлт(-)
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	831,932.9	701,668.5	130,264.4	1,423,723.0	1,199,553.2	224,169.8
Үндсэн цалин	504,847.7	476,805.0	28,042.7	680,090.3	677,550.6	2,539.7
Нэмэгдэл цалин	140,507.9	83,864.2	56,643.7	286,834.1	228,762.2	58,071.9
Унаа хоолны Хөнгөлөлт	82,764.0	65,686.3	17,077.7	86,871.4	68,873.0	17,998.4
Урамшуулал	103,813.3	75,313.0	28,500.3	369,927.2	224,367.3	145,559.9

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,991.6	89,131.5	14,860.1	177,965.5	152,912.6	25,052.9
Тэтгэврийн даатгал	70,714.3	61,095.3	9,619.0	121,016.5	104,978.2	16,038.3
Тэтгэмжийн даатгал	8,319.3	7,187.7	1,131.6	14,237.3	12,368.8	1,868.5
ҮОМШӨ-ний даатгал	6,655.5	5,629.2	1,026.3	11,389.8	9,635.5	1,754.3
Ажилгүйдлийн даатгал	1,663.9	1,382.0	281.9	2,847.5	2,357.3	490.2
Эрүүл мэндийн даатгал	16,638.6	13,837.4	2,801.2	28,474.4	23,572.8	4,901.6
Цалин хөлс НДШ-тэй холбоотой нийт зардлын дүн	935,924.5	790,800.1	145,124.4	1,601,688.5	1,352,465.7	249,222.8
Орон тооны мэдээлэл	57	47	(10)	56	46	(10)

Сэлэнгэ аймгийн Татварын газрын батлагдсан орон тоо 57 байхаас 2022 онд 47, 2023 онд 46 орон тоотойгоор ажиллаж цалин хөлсний нэмэгдэл, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 2022 онд нийт 103,991.6 мянган төгрөг, 2023 онд 177,965.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 2022 онд 89,131.5 мянган төгрөг, 2023 онд 152,912.6 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Сэлэнгэ аймгийн Татварын газрын даргын тушаалаар 2022 онд тус газрын цалинг 2 удаа, албан хаагчдад хоолны хөнгөлөлт, утасны зардал 1 удаа, 2023 онд цалинг 2 удаа, хоолны хөнгөлөлт, утасны зардлыг 2 удаа тогтоосон байна.

- Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал:

Үндсэн цалингийн батлагдсан төсвийг 2022 онд 5.6% буюу 28,042.7 мянган төгрөгөөр, 2023 онд 0.4% буюу 2,539.7 мянган төгрөгөөр, цалингийн нэмэгдэлд батлагдсан төсвийг 2022 онд 40.3% буюу 56,643.7 мянган төгрөгөөр, 2023 онд 20.2% буюу 58,071.0 мянган төгрөгөөр, унаа хоолны хөнгөлөлтөд батлагдсан төсвийг 2022 онд 20.6% буюу 17,077.7 мянган төгрөгөөр, 2023 онд 20.7% буюу 17,998.4 мянган төгрөгөөр, урамшуулалд батлагдсан төсвийг 2022 онд 27.5% буюу 28,500.3 мянган төгрөгөөр, 2023 онд 39.3% буюу 145,559.9 мянган төгрөгөөр, нийт цалин хөлс, болон нэмэгдэл урамшуулалд батлагдсан төсвийг 2022 онд 15.7 % буюу 130,264.4 мянган төгрөгөөр, 2023 онд 15.7% буюу 224,169.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын зардал өмнөх оноос 71.0% нэмэгдсэн байна.

- ЭМНДШ-ийн зардал:

Ажил олгогчоос 12.5%-р тооцон ажилтны төлсөн шимтгэлийн хамт нийгмийн даатгалын байгууллагад шилжүүлж, сар бүр НД8 маягтуудаар тайлагнасан байна. 2022 онд батлагдсан төсвийг 14.3% буюу 14,860.1 мянган төгрөгөөр, 2023 онд 14.1%

буюу 25,52.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна. Нийгмийн даатгалын сангаас 2022 онд жирэмсэн болон амаржсаны болон ХЧТА-ын тэтгэмжид 1,331.5 мянган төгрөг, 2023 онд 1,450.1 мянган төгрөгийг байгууллагын харилцах дансанд шилжүүлснийг тэтгэмж авах албан хаагчдад олгосон байна.

Ажиллагсдын цалин хөлсний тогтоолт, тооцоололт, олголтын байдлыг хяналт шалгалтын явцад цалингийн дэлгэрэнгүй цэсээс хүн тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэл, батлагдсан цагийн тооцоо, нэмэгдэл суутгал, тооцох тушаал шийдвэртэй тулган баталгаажуулахын зэрэгцээ НДШ-ийн дэлгэрэнгүй НД8 тайлантай нэг бүрчлэн тулган шалгаж үзэхэд илүү болон дутуу тооцоолж олгосон нөхцөл байдал илрээгүй болно.

2.8.Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх

- Авлага, өглөг

Татварын газрын үйл ажиллагаанд харилцагч байгууллага нэгж, ажилтан албан хаагчидтай хийх тооцоог тооцооны данс бүртгэлд тусган, төлбөр тооцоог төсвийн жилдээ бүрэн барагдуулсан, өр, авлагын үлдэгдэлтгүй байна.

2021 оны жилийн эцэст 976.2 мянган төгрөгийн авлага, ажиллагсадтай холбогдсон 976.2 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байсныг 2022 онд бүрэн барагдуулан ажилласан байна.

2.9.Иргэн, аж ахуй нэгж байгууллагатай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Татварын газар нь батлагдсан төсвийн хүрээнд харилцагч иргэн, аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажилласан байна..

2.10.Өмнө хийгдсэн шалгалтууд, төлбөр зөрчил, түүний барагдуулалт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн 2022, 2023 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан ба 2022 онд 880.0 мянган төгрөгийн, 2023 онд 840.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгснийг биелэлт 100%-аар бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

ТЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн тоо, мэдээ, харьяа нэгжийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн дагуу гаргасан тайлан, мэдээ, тайлант хугацаанд хийж, гүйцэтгэсэн ажлын тайлан, баримт материал, тайлбар, нотлох зүйлд үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн татварын нэгж, харьяа нэгжийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж үр дүнд үнэлгээ өгсөн байна. Сэлэнгэ аймгийн Татварын газар үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хүрэх түвшний шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дундаж үнэлгээгээр 2022 онд 80.205%-аар “В”, 2023 онд 83.45%-аар “В” үнэлгээ авсан байна.

ТЕГ-ын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газраас 2022, 2023 онд Сэлэнгэ аймгийн Татварын газарт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгээгүй байна.

2.11.Бусад асуудал

-Шилэн дансны мэдээлэл байршуулалт, хуулийн хэрэгжилт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Сэлэнгэ аймгийн Татварын газар нь 2022 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 164-ийг хугацаанд нь мэдээлсэн, 3-ийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. 2023 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

-Татварын хяналт шалгалт

Сэлэнгэ аймгийн Татварын газрын Татварын хяналт шалгалтын тасаг нь чиг үүргийн хүрээнд дараах хийж гүйцэтгэсэн байна. Үүнд

2022 онд төлөвлөгөөт хяналт шалгалтаар 6 татвар төлөгч шалгахаас 6 татвар төлөгчийг шалгаж төлөвлөгөөт бус татвар төлөгчийн болон хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр 27 татвар төлөгч шалгахаас 27 татвар төлөгчийг шалгаж нийт 33 татвар төлөгч татварын хяналт шалгалтад хамруулахаас 100% шалгалтад хамруулж 30 нөхөн ногдуулалтын акт, 3 илтгэх хуудас бичигдсэн. 30 татвар төлөгчид нөхөн ногдуулалтын актаар 12,078,868.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 621,713.6 мянган төгрөгийн нөхөн татвар, 258,728.5 мянган төгрөгийн алданги, 359,976.6 мянган төгрөгийн торгууль, нийт 1,267,418.7 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан. Үүнээс **548,325.5** мянган төгрөг буюу **43.3%**-ийг барагдуулсан байна. Мөн 9 татвар төлөгчийн тайлангаарх алдагдлыг 2,930,474.8 мянган төгрөгөөр бууруулж баталгаажуулсан байна.

2023 онд төлөвлөгөөт хяналт шалгалтаар 48 татвар төлөгч шалгахаас 48 татвар төлөгчийг шалгаж төлөвлөгөөт бус татвар төлөгчийн болон хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр 6 татвар төлөгч шалгахаас 6 татвар төлөгчийг шалгаж нийт 54 татвар төлөгч татварын хяналт шалгалтад хамруулахаас 100 хувь шалгалтад хамруулж 53 нөхөн ногдуулалтын акт, 1 танилцуулга бичигдсэн. 53 татвар төлөгчид нөхөн ногдуулалтын актаар 41,954,226.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 887,793.5 мянган төгрөгийн нөхөн татвар, 251,959.8 мянган төгрөгийн алданги, 351,142.7 мянган төгрөгийн торгууль, нийт 1,490,896.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан. Үүнээс **729,921.7** мянган төгрөг буюу **48.9%**-ийг барагдуулсан байна. 1 татвар төлөгчид танилцуулга бичин цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Мөн 22 татвар төлөгчийн тайлангаарх алдагдлыг 14,329,303.6 мянган төгрөгөөр бууруулж баталгаажуулсан байна.

-Үнэт цаасны тооцоо:

Эргэлтийн хөрөнгийн бараа материалд бүртгэгдсэн үнэт цаасны тооцоог шалгахад 2022 онд 115.3 мянган төгрөгийн үнэт цаасны эхний үлдэгдэлтэй, тайлант онд үнэт цаас аваагүй ба 17.3 мянган төгрөгийн үнэт цаасыг байцаагчдын ажлын хэрэгцээнд, ТЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 03/1322 тоотой хүчингүй болсон ашиглагдахгүй байгаа тооцоот маягтуудыг ирүүлэх тухай албан бичиг, Сэлэнгэ аймгийн Татварын газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн тус татварын газарт ашиглагдаж байсан 2017 онд батлагдсан Шийтгэлийн хуудас-/А5/ нийт 230 ширхэг, Шийтгэлийн хуудас-/А4/ нийт 144 ширхэг бүгд 374 ширхэг шийтгэлийн хуудас Хууль зүйн яамнаас хүчингүй болж цаашид ашиглагдахгүй болсон тул 69.6 мянган төгрөгийн үнэт цаасыг буцааж, 28.4 мянган төгрөгийн үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

2023 онд 28.4 мянган төгрөгийн үнэт цаасны эхний үлдэгдэлтэй, тайлант онд үнэт цаас аваагүй ба 10.6 мянган төгрөгийн үнэт цаасыг байцаагчдын ажлын хэрэгцээнд зарцуулж, 17.8 мянган төгрөгийн үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

Гурав.Шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдал, илэрсэн зөрчил дутагдал

Сэлэнгэ аймгийн Татварын газрын 2022, 2023 оныг хамруулсан санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар журнал хөтлөлт, санхүүгийн тайланг үнэн зөв гаргасан, өмч хөрөнгийн бүртгэлт, хадгалалт хамгаалалт, хангалттай сайн, шилэн дансны цахим хуудасны хөтлөлтөөр, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан зэрэг ололт бүхий нөхцөл байдал тогтоогдсон ба хууль тогтоомжийн хэрэгжилт, төлөвлөлт, татвар ногдуулалттай холбоотой дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудалтай холбоотой зөрчил дутагдал:

1. Алтанбулаг, Баянгол, Ерөө, Мандал, Орхон, Орхонтуул, Хүдэр, Цагааннуур, Шаамар зэрэг сумд ногдуулбал зохих малын тоо толгойн албан татварыг малын тоо толгойд үндэслэн бодитоор ногдуулаагүй **217,301.8** мянган төгрөгөөр дутуу ногдуулсан байна.

Энэ нь Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох: 5.2- "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Малын тоо толгойн татварын орлогын төлөвлөгөөг төсөвлөхдөө өмнөх оны (114,485.6 мянган төгрөгийн) өрийг нэмэгдүүлж үндэслэлгүй төсөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн байна, Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох: 5.2- "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дөрөв. Дүгнэлт, шийдвэрлэлт:

Дүгнэлт:

Сангийн Сайдын баталсан нэгдсэн удирдамжаар Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийсэн хяналт шалгалтаар Сэлэнгэ аймгийн Татварын газар нь 2022, 2023 онд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд төсвийн хөрөнгийг зориулалтаар нь зарцуулж, өмч хөрөнгөнд тавих хяналтыг хэрэгжүүлж, эрхлэх үйл ажиллагааны хүрээнд Татварын хууль, тогтоомжийг сурталчилж, татвар төлөгч нарт мэдээллийг цаг тухайд нь хүргэж ажиллан татварын орлогын төлөвлөгөөг 2022 онд 1,754,684.3 мянган төгрөгөөр, 2023 онд 9,552,154.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлж төсвийн орлого бүрдүүлэн ажилласан боловч малын тоо толгойн татварын орлогын төлөвлөгөөг дутуу төсөвлөж бодитоор ногдуулаагүй байна.

Шийдвэрлэлт:

Сэлэнгэ аймгийн Татварын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар нийт **331,787.4** мянган төгрөгийн зөрчил илэрснийг цаашид дахин давтан гаргахгүй байх санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн 217,301.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 114,485.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

Тав. Цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж:

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Сэлэнгэ аймгийн Татварын газарт хийсэн хяналт шалгалтын дүнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

Сэлэнгэ аймгийн Татварын газрын дарга Ц.ЛХАГВАДОРЖИД ЗӨВЛӨХ нь:

1. Аймаг, сумын малын тоо толгойн татварын орлогын төлөвлөгөөг төсөвлөхдөө Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох: 5.2- "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно." заалтыг үндэслэн төсөвлөх.
2. Малын тоо толгой татвар ногдуулахдаа ногдуулбал зохих малын тоо толгойн албан татварыг малын тоо толгойд үндэслэн бодитоор ногдуулах.
3. Малын тоо толгойн ногдуулсан албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэх.

4. Санхүүгийн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж чиглэлийг ажилдаа хэрэгжүүлсэн тухайгаа Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд 2024 оны 12 дугаар сарын 01-ны дотор албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлэх.

БИЧСЭН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА, СХШУАБ
Т.ОДСҮРЭН
ДОТООД АУДИТОР
СХШУАБ Ц.УРТНАСАН
Х.БАТБААТАР
Г.ДОРЖДЭРЭМ

ТАНИЛЦСАН:
СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТАТВАРЫН
ГАЗРЫН ДАРГА Ц.ЛХАГВАДОРЖ
ЖИЖИГ ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ
ХАРИЛЦАХ ТАСГИЙН ДАРГА,
ТУАБ М.НАРАНЧИМЭГ
ЗАХИРГАА ХҮҮЛИЙН ТАСГИЙН
ДАРГА, ТУАБ О.ЭРДЭНЭХҮҮ
БИЧИЛ ТАТВАР ТӨЛӨГЧТЭЙ
ХАРИЛЦАХ ТАСГИЙН ДАРГА, ТУАБ
Ж.БАТТӨР
НЯГТЛАН БОДОГЧ, ТУАБ
Ш.ЭНХБАЯР